

ҮЗЗ-ийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтын талаар									
ГС-ийн ҮЗЗ		Монгол Улс			Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн тоо			15	
Уулзалтын №		72							
Огноо		2017 оны 2 сарын 10			ҮЗЗ-ийн гишүүн бус оролцогчдын тоо, уригдаж ирсэн зочид			11	
ХУРЛЫН ДАРГА									
Нэр/ Байгууллага		Овог	Бямбасүрэн			Хурлын зорилгод хүрсэн эсэх (тийм, үгүй)			ТИЙМ
		Нэр	Мягмар			Хурлын үргэлжилсэн хугацаа (цагаар)			4
		Байгууллага	МУЭ, Монголын Эрүүл Мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга			Хурал зохион байгуулагдсан газар	Скай плаза, хурлын танхим		
ҮЗЗ-д гүйцэтгэх үүрэг (Төхирөх нүдийг бөглөнө үү)		Дарга			x	Уулзалтын төрөл (Төхирөх нүдийг бөглөнө үү)		Ээлжит	X
		Дэд дарга						Ээлжит бус	
		Гишүүн						Хорооны уулзалт	
		Гишүүнийг орлогч						Бусад байгууллагын оролцоо (Төхирөх нүдийг бөглөнө үү)	СОНА
Салбар * (Төхирөх нүдийг бөглөнө үү)								FPM / PO	
ЗГ	ОУБ	ТББ	Боловсрол	Өвчлөлт бүлгийн хүн ам	Эрсдэлт бүлгийн хүн ам	Шашны Байгууллага	Хувийн Хэвшил	бусад	X
							x	оролцоогүй	

ХӨТӨЛБӨР ТУС БҮРТ ХАМААРАХ СЭДВИЙГ СОНГОНО УУ (Төхирөх нүдийг бөглөнө үү)															
ҮЗЗ-ийн ЗАСАГЛАЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ СЭДВҮҮД															
№	Хөтөлбөрийг дурдана уу	Ажлын явц	ҮЗЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийг хянах	АСЗ	ҮЗЗ-ийн гишүүнчлэлийн асуудал	Тогтвортой байдал	ҮЗЗ болон хамтрагч байгууллагуудын уялдаа холбоо	Хүйсийн эрх тэгш байдал	Төсөл боловсруулах	УХА, СХА	Тэтгэлэг	Хяналт (удирдлага, СОНА аудит)	Санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох талаар / төслийн II үе/, хаалт	Техникийн тусалцаа авах шалгаруулалт	Бусад
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт											X			
Хөтөлбөр #2	ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн одоо хэрэгжиж буй төслүүдийн дахин төлөвлөлтийг танилцуулах	X				X						X	X		
Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжих ХДХВ/ДОХ-ын Үргэлжлэх шатны төсөл боловсруулах үйл ажиллагааны явцыг танилцуулах, хөтөлбөрийн хуваарилалтыг хэлэлцэх	X						X					X		
Хөтөлбөр #4	ҮЗЗ-ийн дарга, дэд даргын асуудал				X							X			
Хөтөлбөр #5	Бусад: Бүсийн менежер Манабын айлчлал						X		X		X			X	X

Хөтөлбөр тус бүрээр хийсэн тэмдэглэл

Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт
--------------------	---

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх(тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

А.Нямдорж: ҮЗЗ-ийн дэд дарга Нямдорж хурлыг даргалан хурлын хөтөлбөрийг гишүүдэд танилцуулж, гишүүд саналгүй тул хөтөлбөрийг батлав. 71 дэх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулав.

ҮЗЗ-ийн 71 дэх хурлын шийдвэрийн гүйцэтгэл		2017-1-25-нд болсон	
хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	Гүйцэтгэл
хөтөлбөр#2	Дүрмийн шинэчлэлтийг хийсэн.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	100%
хөтөлбөр#4	<ul style="list-style-type: none"> Сүрьеэгийн төслийн нэмэлт санхүүжилтийн саналыг Хяналтын хорооны зөвлөмж болон ДЭМБ-ын мэргэжил арга зүйн зөвлөгөөг тусган хэрэгжүүлэхийг гишүүдийн 72,5%-ийн саналаар батлав. ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслийн дахин төлөвлөлтийн саналыг ГХ, ХХ-аар оруулж хэлэлцүүлгийн дүнд ээлжит хурал хийж шийдвэрлэх болсон. 	ҮЗЗ-Н ГИШҮҮД	100%
хөтөлбөр#5	<ul style="list-style-type: none"> ДОХ-ын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон хуралдаж байна. Сүрьеэгийн Ажлын хэсэгт оролцох хүмүүсийг баталсан. 	ДОХ-ын Ажлын хэсгийн ахлагч А.Нямдорж, Сүрьеэгийн Ажлын хэсгийн ахлагч Б.Мягмар.	In process
хөтөлбөр#8	Ашиг сонирхолын зөрчлийн хороог байгуулсан.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	100%

Хөтөлбөр #2**ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн одоо хэрэгжиж буй төслүүдийн дахин төлөвлөлтийг танилцуулах**

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

- ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслийн хэмнэгдсэн төсвийн дахин төлөвлөлтийн танилцуулга /Хавсралт 2/ ХЗН-ийн зохицуулагч А.Оюунбилэг танилцуулав.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

А.Оюунбилэг: ЭМЯ-тай хамтран бэлтгэсэн ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслийн дахин төлөвлөлтийн талаар дэлгэрэнгүй тайлбарыг хийлээ. Мөн Өмнөговь аймгийн Цогцэций, Ханбогд сумдад сүрьеэ маш өндөр тархалттай байгаа бөгөөд ихэнх хувийг хил дээр байдаг цэргийн ангийн цэргүүд эзэлж байдаг. Сумын эмнэлгийн хувьд 3 давхар байшин байдаг бөгөөд байшингийн хувьд асуудалгүй. Харин рентгений хоронд эмч нар нь ихээхэн хорддог учраас тусгай хамгаалалтын тугалган хана шаардлагатай байгааг сольж өгөх болсон. Энэхүү мэдээллийг өнөөдөр өглөө ҮЗЗ-ийн Гүйцэтгэх Хорооны гишүүдэд танилцуулж зохих заавар зөвлөмж, болон зарим өөрчлөлтүүдийг оруулан шинэчлэснээр батлах болсон. Олон жилийн үлдэгдлүүд хураагдсан учир дахин төлөвлөлт хийх боломжтой. Үндсэндээ ярилцаад 2 өрөөний нэгийг нь зөвшөөрсөн. Нэгэнд нь өөр ажил тусгасан. Сүрьеэтэй өвчтөнүүдэд тусламж үзүүлж байгаа эмнэлгийн нөхцөл муу байна. Үүнийг дахин төлөвлөлтөнд тусгая.

- ДОХ сүрьеэ хавсарсан олон нийтэд мэдээлэл олгох
- Эмч, сувилагч нарт боловсрол олгох сургалт хийх
- Сүрьеэгийн эрт илрүүлэлт үзлэг оношилгоо сайжруулах, рентген аппарат авах гэх мэт үйл ажиллагаа дэмжигдсэн

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Залуусын байгууллага	А.Нямдорж: ДОХ, Сүрьеэгийн дахин төлөвлөлтийн тооцооллыг удаа дараа танилцуулж байна. 4 удаагийн хурлаар сайжирч орж ирж байна. Энэхүү төлөвлөгөө нь өмнөх төлөвлөгөөг бодвол илүү сайжирсан. ДОХ-ын дахин төлөвлөлт, эрт илрүүлэлт дээр халдварт өвчний дэгдэлт ихтэй байгаа аймгуудад үзлэг шинжилгээ хийнэ. Нөлөөллийн ажлуудыг хийх. 2017 онд Нийгмийн эрүүл мэнд жил болгон зарласан төрийн бодлогыг дэмжсэн үйл ажиллагааруу чиглэн ажиллах нь чухал билээ.
ТБ	Л.Бямбасүрэн: Аль суманд тугалган хана болон рентген аппарат солих вэ?
Хариулт:	

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Шийдвэр: Одоо хэрэгжиж буй ДОХ-ын төслийн дахин төлөвлөлтийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогцэций, Ханбогд сумдаас нэгийг нь сонгон тугалган хана болон рентген аппарат солих болно. Зардлын 50 хувийг Улаанбаатар хотын дүүргүүдийн Эмнэлгийн ажилчдын дунд халдвар авах магадлал өндөр байгаа учраас үүнд шаардагдах тусламж дэмжлэг, эмнэлгийн орчныг сайжруулах, халдвараас урьдчилан сэргийлэх ажилд анхаарал хандуулах шаардлагатай гэж шийдсэнийг гишүүд бүгд гараа өргөн баталлаа.

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Төхирөх нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		15
		Эсрэг>		
			Санал өгөхөөс түтгэлзэх	

Хөтөлбөр #3 2018-2020 онд хэрэгжих ХДХВ/ДОХ-ын Үргэлжлэх шатны төсөл боловсруулах үйл ажиллагааны явцыг танилцуулах, хөтөлбөрийн хуваарилалтыг хэлэлцэх

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

байхгүй

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Тийм

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

А.Нямдорж: Глобал сангаас Монгол улсыг 2018-2020 онд хэрэгжүүлэх ХДХВ/ДОХ, Сүрьеэ болон эрүүл мэндийн уян хатан, тогтвортой системийг бий болгоход 10,269,067 ам.долларын төслийг боловсруулан хүргүүлэх боломжийг олгосон. Үүнээс 3,044,708 ам.долларын санхүүжилт нь ХДХВ/ДОХ-ын үргэлжлэх шатны төсөлд, 7,224,359 ам.долларын санхүүжилт нь Сүрьеэгийн төсөлд тус тус хуваарилагдах юм. ХДХВ/ДОХ-ын төслийн санал хүлээн авах сүүлийн хугацаа нь 2017 оны 3-р сарын 20-ны өдөр, Сүрьеэгийн төслийг 2017 оны 5-р сарын 23-ны өдөр өргөн барих болно. Та бүхэнд энэхүү хуваарилалттай холбоотой санал байвал одоо хэлж болно. Үндэсний зөвлөхөөр Т.Отгонбаатар, олон улсын зөвлөхөөр Тед Ниеррас, Скот Берри нарыг ажиллуулахаар Гүйцэтгэх хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн. ДОХ-ын Ажлын хэсгийн ахлагч А.Нямдорж ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 4 удаа хуралдсан ба олон талт зөвлөлдөх уулзалтыг амжилттай зохион байгуулсан. Тэдгээрээс гарсан санал зөвлөмжүүдийг төсөлдөө тусган ажиллах саналууд аваад явж байна. Сүрьеэгийн Ажлын хэсгийн ахлагчаар Б.Мягмар ажиллаж байна.

Б.Мягмар: Сүрьеэгийн ажлын хэсэгт дараах байгууллагуудаас төлөөлөл оруулах саналтай байна. Үүнд:

1. ЭМЯ-3
2. ҮЗЗ-2
3. ХЗН-6 /ХЗН саналаар/
4. ХӨСҮТ-4, СТСА, СК (Сүрьеэгийн клиникээс 1 хүн заавал оруулах)
5. ДЭМБ-1
6. МӨАҮМХ (Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо)-1
7. МСТН (Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэг)-1
8. АШУҮИС-1
10. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв-1
11. МУЗН (Монголын улаан загалмайн нийгэмлэг)-1
12. Өвчтөний төлөөлөл-1
13. Монголын эрүүл мэндийн үүсгэл ТББ-1

14. ХЗН санал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-1
 15. НЭМГ-1
 Нийт 24 оролцогчтой байна.
 Зөвлөхөөр: н.Цогт, ЭМЯ-ны Сүрьеэгийн ерөнхий мэргэжилтэн

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ХЗН	А.Оюунбилэг: ДОХ-ын төслийн өмнөх 3 жилийн үйл ажиллагааны төсөв нь 5 сая ам.доллар байсан бөгөөд 2017-2020 онд хэрэгжих үргэлжлэх шатны төсөлд 3 сая ам.доллар хуваарилсан ба эрүүл мэндийн бат бөх, тогтвортой систем, түлхүүр хүн ам, ЭМ-ийн стратеги нэмэгдвэл санхүүжилт нь хангалттай биш юм. Тиймээс Сүрьеэгийн төслийн санхүүжилтээс 1,5 сая ам.доллар ДОХ-ын төсөлд шилжүүлэх саналтай байна. Түүнчлэн сүрьеэгийн шинэ төсөл учраас бүх салбар хүлээн авагчийн оролцоог хангах олон талт үйл ажиллагаа явуулах үүднээс ажлын хэсгийн гишүүнчлэлийн асуудлыг нээлттэй байлгах саналтай байна. Манай ХЗН-ээс зайлшгүй 6 мэргэжилтэн орж ажиллан цаашдын үйл ажиллагаанд оролцох шаардлагатай байдаг.
ХӨСҮТ	Б.Буянхишиг: Монгол орны хувьд сүрьеэгийн тархалт эрчимтэй нэмэгдэж байгаа тул хийх ажил ч маш их байна. Тиймээс 1 сая доллараас дээш шилжүүлэх боломжгүй.
ХЗН	Ч.Бямбаа: Бидний үзэж байгаагаар үндэсний зөвлөхийг ажлын хэсгээрээ хэлэлцэн томилох нь зарчмын хувьд илүү тохиромжтой санагдаж байна. Гүйцэтгэх болон Хяналтын хороо хэт их эрх мэдэлтэй бөгөөд бүх зүйлсийг шийдвэрлээд яваад байгаа байдал ажиглагдаад байна.
ХЗН	М.Сэргэлэн: ДОХ-ын төслийн зөвшөөрөгдсөн мөнгөн дүндээ бичээд нэмэлт /above allocation/-ээр 2 сая.долларт бичиж болно. Эсвэл 2 төслөө зэрэг бичээд саналуудаа гаргаад явбал хаанаас хэд хэмнэгдэх боломжтойг харж болох юм. Тэгэснээр төсвийн тооцооллыг хийхэд аль аль талдаа тулгуур болж өгч чадна.
АШУИС	Д.Даваадорж: Энэ хуваарилалтыг Глобаль сангаас багцаалан ирүүлсэн учраас өөрчлөх бодолгүй байна.
ТББ	Ц.Ганхүү: Миний зүгээс харахад хэдхэн хүн бүх удирдлагыг гартаа авсан мэт харагдаад байна. Тиймээс Гүйцэтгэх Хорооны дарга болон дарга, дэд даргын албан тушаалын хугацааг бууруулах эсвэл даргыг ээлжлэн хийж байх саналтай байна. Ер нь дандаа л Гүйцэтгэх Хорооны хурлаар тэгэж шийдсэн байгаа та бүхэн дэмжиж байна уу гэж тулгасан байдалтай саналуудыг оруулж ирж батлуулж байна.
ТБ	Л.Бямбасүрэн: Хэрэв та бүхэн Гүйцэтгэх Хорооны хурлаар шийдвэрийг гаргадаг юм бол ядаж 2-3 хувилбартайгаар санал гарган гишүүдэд танилцуулж саналыг нь авч батлуулах нь зүйтэй. Тэгэхгүйгээр ийм шийдвэрт хүрсэн гээд гараа өргө гээд байх нь тун зохимжгүй байна. Түүнчлэн МУ-д мөрдөгдөж буй хуулийн дагуу хуульч эсвэл зөвлөхтэй байх хэрэгтэй байна. Түүнээс гадна хурлын дэгийг батлах хэрэгтэй байна. Эдгээр шаардлагуудыг ханган зарчмын дагуу ажиллах шаардлагатай байгааг анхаарна уу. Тиймээс хамтран шийдэхгүй юм бол ямар ч шаардлагагүйгээр цаг үрэх гэж ирэх хэрэг алга.

Харнулт:

Б.Мягмар: Ер нь МУ-ын хувьд сүрьеэгийн асуудал маш их эрчимтэй газар авч байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд энэ хөрөнгө хүрэх эсэх нь эргэлзээтэй байгаа, тиймээс яг одоо шилжүүлэх үгүйгээ тогтсон нь бидний хувьд илүү дээр байхаар байна. Шинэ төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сонгохдоо цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох боломжтой гэдэг үүднээс сонгосон. Тиймээс байгууллага дотроо бол ямар ч өргөн бүрэлдэхүүнээр ажиллан саналаа тусгах боломжтой бөгөөд энд ирж танилцуулахдаа төлөөллийн хүн байвал илүү оновчтой байх болно гэдэг үүднээс энэхүү шийдвэрийг гаргалаа.

Шийдвэр:

Хуралд оролцогчид харилцан тохиролцсоны үндсэн дээр Сүрьеэгийн төслөөс хамгийн ихдээ 1 сая ам.доллар шилжүүлэх боломжтой гэсэн шийдвэр гаргасан.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		14
		Эсрэг>		
			Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #4	ҮЗЗ-ийн дарга, дэд даргын асуудал
--------------------	--

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Тийм

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

А.Нямдорж: Глобаль санд төсөл өргөн барьж байгаа энэ чухал цаг үед ҮЗЗ-ийн даргын асуудал маш чухал бөгөөд бид энэхүү хурлаараа ҮЗЗ-ийн даргаар хэн ажиллах вэ гэдгийг шийдвэрлэх шаардлага үүсээд байгаа билээ. Миний хувьд дэд даргынхаа үүргийг гүйцэтгээд явах саналтай байна. Тиймээс та бүхэн өөр өөрсдийн саналыг хэлнэ үү.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

АШУИС	Д.Даваадорж: Миний хувьд ТБ-ын ажилтан биш мөн хувийн шинж чанараас нь харахад Б.Мягмар даргыг нэр дэвшүүлэх саналтай байна.
ТБ	Л.Бямбасүрэн: Энэхүү ҮЗЗ-ийн дүрмээс харахад СХА-ын төлөөлөл ҮЗЗ-ийн даргаар ажиллах боломжгүй гэж бичээгүй байна. Тиймээс би Ц.Ганхүүг санал болгож байна. Түүнчлэн миний бие Гүйцэтгэх Хорооны гишүүнээр элсэн ажиллах саналтай байгааг хүлээн авна уу. Учир нь энэхүү төслийн хүрээнд яг юу болж байгааг мэдэх шаардлагатай байгаад байна. Хэрэв зарчмын дагуу явдаг бол заавал орох гээд байхгүй бөгөөд миний өөрийн үндсэн ажил үнэхээр их байдаг.
ДЭМБ	Ж.Нарантуяа: Би ч бас Ц.Ганхүүг ҮЗЗ-ийн даргад нэр дэвшүүлэхийг дэмжиж байна. Учир нь Б.Мягмар гишүүн Хяналтын хорооны даргаараа ажиллах нь бас чухал байна.
ТББ	Ц.Ганхүү: Би ч бас энэхүү үйл ажиллагаатай сайн танилцаж цаашдын хөтөлбөрүүдийн талаар илүү их мэдээ, мэдээлэл авах хүсэлтэй байна.

Харуулт:

Б.Мягмар: ЭМ-ийн дэд сайд Гүйцэтгэх Хороонд гишүүнээр орох асуудлыг дараа долоо хоногт Манабыг ирэхэд илүү сайн тодруулаад та бүхэнд мэдэгдэе. Миний хувьд ҮЗЗ-ийн дүрэмд тэр талаарх асуудлыг тусгаагүй тул гишүүн болох боломжтой гэж бодож байна.

Шийдвэр:

1. ҮЗЗ-ийн дарга Б. Мөнхцэцэгийн орлон гүйцэтгэгчээр Б.Мягмарыг гишүүдийн 80%-ийн саналаар томилох шийдвэр гарсан бөгөөд дараах шалтгаануудын улмаас энэхүү шийдвэрийг гарган баталсан болно. Үүнд:
 - Төсөл өргөн барих цаг үе ойртсон.
 - Онцгой тохиолдол- хүүхэд төрүүлэх амралтаа авсан
 - Чөлөөлөгдөх хугацаа тодорхойгүй зэргээс үүдсэн болно.
2. Хяналтын хорооны дарга ҮЗЗ-ийн дарга болсонтой холбогдуулан тус хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг хангах үүднээс Ц.Ганхүү, Ч.Энхтамир нарыг нэмж оруулсан. Түүнчлэн ҮЗЗ-ийн ажлын албанд Хяналтын хорооны ээлжит хурлыг яаралтай зарлан хуралдуулж даргыг нь дотроо хуралдан сонгох ажлыг эрчимжүүлэхийг үүрэг болгон өглөө.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х				
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх		х
			Нууц санал хураалт		
		Дэмжсэн>			12
		Эсрэг>			
Санал өгөхөөс түдгэлзэх				2	

Хөтөлбөр #5	Бүсийн менежер Манабын айлчлал
--------------------	---------------------------------------

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

А.Нямдорж: Сангийн менежер Ноён Манаб Баснетын Монгол улсад айлчлах айлчлалын хөтөлбөр болон айлчлалын хугацааг ҮЗЗ-ийн бусад гишүүдэд танилцууллаа. Түүнчлэн ЭМЯ-аас Циклосерин эмийн талаар авсан хариу арга хэмжээний албан бичгийг ҮЗЗ-ийн ажлын албанд өгч, танилцуулуулах шаардлагатай гэдгийг дурдсан болно.

Огноо	Цаг	Үйл ажиллагаа	Хариуцагч	Байршил
Хоёрдугаар сарын 13, Даваа гариг		Ирэх	ХЗН	"Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал
	10:30	ҮЗЗ-ийн дэд дарга, Хяналтын Хорооны даргатай уулзах	ҮЗЗ-ийн ажлын алба	ҮЗЗ-ийн байр
	<i>Үдийн хоол</i>			
	13:00– 15:00	Техникийн ажлын хэсэгтэй уулзах	ҮЗЗ-ийн ажлын алба	Скай плаза, А хурлын танхим
	15:30-17:00	СОНА-ын багтай уулзах	СОНА-ын байр	СОНА-ийн байр
Хоёрдугаар сарын 14, Мягмар гариг	09:00-12:00	ХЗН дээр ажиллах	ХЗН-ийн баг	ХЗН-ийн байр
	<i>Үдийн хоол</i>			
	13:00-14:30	ХӨСҮТ-ийн албан тушаалтнуудтай уулзах	СТА	ХӨСҮТ
	14:30-17:00	ХӨСҮТ-ийн албан тушаалтнуудтай уулзалт	ХДХВ-ын хэлтэс	ХӨСҮТ
Хоёрдугаар сарын 15, Лхагва гариг	09:00-10:00	Төрийн Нарийн Бичгийн даргатай уулзах	ЭМЯ	ЭМЯ-ны байр
	10:00-12:00	ДЭМБ-ын төлөөлөгчтэй уулзах	ЭМЯ	ДЭМБ-ын байр
	<i>Үдийн хоол</i>			
	13:00-17:00	ХЗН дээр ажиллах	ХЗН	ХЗН-ийн байр
Хоёрдугаар сарын 16, Пүрэв гариг		Буцах		"Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#2	Өмнөговь аймгийн Цогцэций, Ханбогд сумдаас нэгийг нь сонгон тугалган хана болон рентген аппарат солих болно. Эмнэлгийн ажилчдын дунд халдвар авах магадлал өндөр байгаа учраас үүнд шаардагдах тусламж дэмжлэг, эмнэлгийн орчныг сайжруулах, халдвараас урьдчилан сэргийлэх ажилд анхаарал хандуулах шаардлагатай гэж шийдсэнийг гишүүд бүгд гараа өргөн баталлаа.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	
хөтөлбөр#3	Хуралд оролцогчид харилцан тохиролцсоны үндсэн дээр Сүрьеэгийн төслөөс хамгийн ихдээ 1 сая ам.доллар шилжүүлэх боломжтой гэсэн шийдвэр гаргасан.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	

хөтөлбөр#4	<p>3. ҮЗЗ-ийн дарга Б. Мөнхцэцэгийн орлон гүйцэтгэгчээр Б.Мягмарыг гишүүдийн 80%-ийн саналаар томилох шийдвэр гарсан бөгөөд дараах шалтгаануудын улмаас энэхүү шийдвэрийг гарган баталсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төсөл өргөн барих цаг үе • Онцгой тохиолдол- хүүхэд төрүүлэх амралтаа авсан • Чөлөөлөгдөх хугацаа тодорхойгүй зэргээс үүдсэн болно. <p>4. Хяналтын хорооны дарга ҮЗЗ-ийн дарга болсонтой холбогдуулан тус хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг хангах үүднээс Ц.Ганхүү, Ч.Энхтамир нарыг нэмж оруулсан. Түүнчлэн ҮЗЗ-ийн ажлын албанд Хяналтын хорооны ээлжит хурлыг яаралтай зарлан хуралдуулж даргыг нь сонгох ажлыг эрчимжүүлэхийг үүрэг болгон өглөө.</p>	ҮЗЗ-ийн гишүүд	
------------	--	----------------	--

ДАРААГИЙН ХУРАЛ(ОГНОО, ХӨТӨЛБӨР)

Огноо	2017 оны 3 дугаар сар
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	


БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирох нүдийг бөглөнө үү)

	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон оролж ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:

Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НУБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
АСЗХ	Ашиг сонирхлын зөрчлийн хороо
ЭМ	Эрүүл Мэнд

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2017 оны 2 сарын 10
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	

БАТАЛСАН:

Нэр>	Б.Мягмар	DATE >	2017 оны 2 сарын 10
Албан тушаал>	ҮЗЗ-ий дарга	Гарын үсэг>	